

ХАСБАНК ХК (“ХАСБАНК” ЭСХҮЛ “БАНК”)-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2023 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДРИЙН БААСАН ГАРАГИЙН 13:00-15:50 (УЛААНБААТАРЫН ЦАГААР) ЦАГИЙН ХООРОНД МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, БЛЮ СКАЙ ЗОЧИД БУУДАЛ, 3 ДУГААР ДАВХАР, ХУРЛЫН ДАЙМОНД ТАНХИМД ХУРАЛДСАН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ОГНОО БА ХУРАЛДСАН ГАЗАР

Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“ХЭЭБХ”) 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн Баасан гарагийн 13.00-15:50 цагийн /Улаанбаатарын цагаар/ хооронд Монгол Улс, Улаанбаатар хот, Блю Скай Зочид Буудал, 3 дугаар давхар, хурлын Даймонд танхимд хуралдав. Хурал танхим болон цахим хосолсон байдлаар зохион байгуулагдав.

ХЭЭБХ-ыг монгол хэлээр хөтлөн явуулж, илтгэлүүдийг мөн монгол хэлээр тавьсан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Санжай Гүптагийн англи хэл дээр илтгэсэн нээлтийн үг болон бусад яриаг монгол хэл дээр шууд хөрвүүлэн хүргэв.

1. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ИРЦ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн дагуу, ХЭЭБХ энгийн олонх оролцсоноор буюу Компанийн нийт энгийн хувьцааны 50%+1 хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид биечлэн эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцсоноор хүчин төгөлдөр болохыг тэмдэглэв.

Тооллогын комиссын дарга Э.Ундармаа, Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2023 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн R-2023-66 дугаар тогтоолоор банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарласныг дурдаж, банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийг зарлав. Банкны гаргасан нийт 1,052,700,000 (нэг тэрбум тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг энгийн хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдээс 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн ХЭЭБХ-д 1,005,877,108 (нэг тэрбум таван сая найман зуун далан долоон мянга нэг зуун найм) ширхэг энгийн хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсон тул хурлын ирц 95.55% (ерэн тав зууны тавин тав) хувиар бүрдсэнийг зарлав.

Ийнхүү, Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг мэдэгдэв.

ХЭЭБХ-д дараах бусад оролцогчид оролцов.

ТУЗ-ийн гишүүд

- | | | |
|---|-------------------|---|
| 1 | Санжай Гүпта | ХасБанкны ТУЗ-ийн дарга |
| 2 | Г.Цэвэгжав | ХасБанкны Гүйцэтгэх захирал ба ТУЗ-ийн гишүүн (“Гүйцэтгэх захирал”) |
| 3 | Б.Уламбаяр | ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн |
| 4 | Нираж Вэдва | ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн |
| 5 | Эми Чой | ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн |
| 6 | Майкл Мадден | ХасБанкны ТУЗ-ийн гишүүн |
| 7 | Н.Цэлмүүн | ХасБанкны ТУЗ-ийн гишүүн (цахим хэлбэрээр оролцсон) |
| 8 | Албертус Браггинк | ХасБанкны ТУЗ-ийн гишүүн (цахим хэлбэрээр оролцсон) |
| 9 | Анджей Витак | ХасБанкны ТУЗ-ийн гишүүн (цахим хэлбэрээр оролцсон) |

Гүйцэтгэх удирдлага

- | | | |
|---|--------------|---|
| 1 | Г.Эрдэнэбаяр | Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Санхүү хариуцсан захирал |
| 2 | Э.Уламбаяр | Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирал |

3	Б.Еркин	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Байгууллагын банк хариуцсан захирал
4	С. Дауренбек	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Лизинг хариуцсан захирал
5	Илия Аврамов	Эрсдэл хариуцсан захирал
6	Г.Зул	Үйл ажиллагаа хариуцсан захирал
7	Х.Өнөрбат	Мэдээллийн технологи хариуцсан захирал
8	Н.Мөнхцэлмэг	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Хууль хариуцсан захирал (“ХХЗ/ТУЗНБД”)
Тооллогын комисс		
1	Э.Ундармаа	ХасБанкны Ерөнхий аудитор
2	Э.Мөнх-Эрдэнэ	ХасБанкны Хуулийн хэлтсийн захирал
3	Б.Биндэрьяа	ХасБанкны Газар дээрх аудитын хэлтсийн захирал

ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүд болох Б.Уламбаяр, Нираж Вэдва болон Эми Чой нар нь Хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулахаар биечлэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцов.

2. ХУРЛЫН НЭЭЛТ

Банкны Дүрмийн 8.7 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн дарга Санжай Гүпта (“Хурлын дарга”) ХЭЭБХ-ыг даргалав.

Хурлын дарга ХасБанк ХК-ийн ХЭЭБХ-д оролцож буй нийт хувьцаа эзэмшигчиддээ талархал илэрхийлээд нээлтийн үг хэлэв:

“ХасБанк нь хувьцаат компани болон өөрчлөн байгуулагдсанаас хойш зохион байгуулагдаж буй хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хуралд хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүлээн авч угтаж буй нь миний хувьд нэр төрийн хэрэг байна.

Оны эхний 6 сарын байдлаар банкны цэвэр ашиг нийт 62 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27% өссөн нь дахин нэгэн түүхэн амжилт болсныг та бүхэнд уламжлахад таатай байна. Өнөөдрийн байдлаарх банкны үйл ажиллагааны гүйцэтгэлийг дүгнэж үзвэл энэ оны хэтийн төлөв тун өөдрөг харагдаж байна. 2019 оны эхэнд авч хэрэгжүүлсэн бүтцийн өөрчлөлт болон шинэ стратегийн хэрэгжилт нь банкиг жил дараалан түүхэн амжилт тогтооход ихээхэн нөлөөлсөн. Хамтдаа энэ оны түүхэн амжилтыг тэмдэглэнэ гэдэгт итгэлтэй байна.

Банкны салбарт 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээгээр тэргүүлж буй банкуудын нэг нь манай банк билээ. Монголбанкны зохистой харьцаа үзүүлэлтээр 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг 12.5%-иас дээш байхыг шаарддаг бол манай банкны үзүүлэлт 19% гаруй байна. Өөрийн хөрөнгийн хэмжээ өндөр байх нь өөрийн хөрөнгийн өгөөжийг бууруулдгийг та бүхэн мэдэх байх. Гэсэн хэдий ч манай Банк өөрийн хөрөнгийн өгөөжөөр салбартаа тэргүүлэгчдийн нэгт зүй ёсоор багтаж байна.

Мөн Зээлийн багцийн чанар болон байгуулсан сангийн хэмжээгээр манай Банк салбартаа тэргүүлдэг.

ХасБанкны хамт олон бид хувьцаа эзэмшигчиддээ үнэ цэнийг бүтээхийн төлөө цаг ямагт шаргуу хөдөлмөрлөхийг эрхэмлэдэг. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд бид онцгой амжилт гаргасан бөгөөд ирээдүйд ч амжилт ололтоо ахиулна гэдэгт итгэлтэй байна.”

3. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

Хурлын дарга ХЭЭБХ-ын хэлэлцэх асуудлыг ТУЗ-өөс баталж, нийт хувьцаа эзэмшигчдэд зохих журмын дагуу урьдчилан танилцуулсан гэдгийг дурдав. Хурлын хэлэлцэх асуудлыг хувьцаа эзэмшигчдэд дараах байдлаар танилцуулав.

Танилцуулах асуудал:

- Банкны 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтын явцын мэдээлэл;
- Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай; мөн
- Хувьцаат компанийн дүрмийн төслийн танилцуулга.

Шийдвэрлэх асуудал:

- Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай тогтоолын төслийг батлах эсэх; мөн
- Банкны Дүрмийг батлах тухай тогтоолын төслийг батлах эсэх.

Хурлын дарга Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавыг ХасБанкны 2023 оны эхний хагас жилийн үр дүнг хувьцаа эзэмшигчдэд танилцуулахыг урив.

4. ХАСБАНКНЫ 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав ХасБанк ХК-ийн ХЭЭБХ-д хүрэлцэн ирсэн хүн бүрийг халуун дотноор угтан авч талархлаа илэрхийлэв. ХасБанкны хувьцаат компани хэлбэрээр хийж буй анхны ХЭЭБХ гэдгийг тэмдэглээд, өнөөдөр хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид чухал үйл явдлын нэгээхэн хэсэг болж буй гэж онцлов.

Тэрээр илтгэлээ 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн гол үзүүлэлтүүдээр эхлүүлэв. Үүнд: цэвэр ашиг 62.2 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 27%-иар өссөн, нийт актив 4.2 их наяд төгрөг болж, он гарсаар 8.1%-ийн өсөлттэй, мөн чанаргүй зээлийн хувь 2.9% байна.

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ 19.1%, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 36.6% байна.

Үргэлжлүүлэн, Гүйцэтгэх захирал Банкны чухал амжилтуудыг онцлов. ХасБанк 35.7 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр 52.7 сая ширхэг хувьцааг анх удаа олон нийтэд санал болгосон бөгөөд анхдагч зах зээлээс 41.8 тэрбум төгрөгийн захиалга ирж, арилжаа 117.2%-ийн биелэлттэй хаагдаж, Монголын хөрөнгийн бирж ("МХБ")-д бүртгэлтэй компани болсон гэлээ.

Дараа нь тэрээр гадаадын зах зээлээс эх үүсвэр амжилттай татсан талаар танилцуулж, ХасБанк бичил, жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүд болон ногоон бизнесийг дэмжих зорилгоор Олон улсын санхүүгийн корпораци ("ОУСК") болон Нидерландын хөгжлийн агентлагаас нийт 105 сая ам.долларын эх үүсвэр татсан, уг эх үүсвэрийг Монгол Улсад эрчим хүчний хэмнэлттэй бизнес, төслүүдийг санхүүжүүлэхэд зарцуулна гэв.

Нэгдсэн үндэсний байгууллага ("НҮБ")-ын Уур амьсгалын ногоон сан ("УАНС")-аас хоёр дахь удаагаа магадлан итгэмжлэгдэж, УАНС-тэй магадлан итгэмжлэлийн мастер гэрээ байгуулсан.

Мөн, Монгол Улсын Засгийн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим ("МҮХАҮТ")-аас зарладаг "ТОП 100 ААН"-ын шагналыг ХасБанк дахин хүртсэн байна.

Гүйцэтгэх захирал цалингийн хадгаламж, ипотекийн зээл, картын буцаан олголт, онлайн цалингийн зээл, түүнчлэн хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл болон бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зэрэг банкны үндсэн үйлчилгээний талаар дурдаж, онцлох гүйцэтгэлийг танилцуулав. Үүнд: цахимаар олгосон цалингийн зээл 58.8 тэрбум төгрөг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга, Засгийн газрын хөтөлбөрийн дагуу хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд олгосон зээл 73.7 тэрбум төгрөг байна. Мөн эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгын хүрээнд 202 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Түүнчлэн дижитал хэрэглэгчдийн тоо 27.1%-иар, ПОС терминалын хэрэглээ 28.0%-иар, нийт гүйлгээ 17.0%-иар өссөн гэлээ. Харилцах дансны үлдэгдэл харилцагчийн бизнесийн улирлын онцлог, мөнгөн урсгалаас хамаарч бага зэрэг буурсан үзүүлэлтэй байна.

ХасЛизинг буюу Лизингийн Газрын багцын хэмжээ 313.3 тэрбум төгрөгт хүрч, 2022 оны эцсийнхээс 41%-иар буюу 90.8 тэрбум төгрөгөөр мэдэгдэхүйц өссөн байна. Эко лизингийн хувьд, байгаль орчинд ээлтэй цахилгаан автомашиныг хөнгөлөлттэй нөхцөлтэй санхүүгийн түрээсээр санхүүжүүлж байгаа бөгөөд нийт 7.0 тэрбум төгрөгийн цахилгаан автомашины санхүүжилтийг олгосон. "1 ӨДӨРТ" шийдвэрлэдэг Хаус худалдан авах зээлийн үйлчилгээ нэвтрүүлээд байна.

Үргэлжлүүлэн, Гүйцэтгэх захирал Банкны ашигт ажиллагаа болон активын талаар танилцуулж, сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлж буй стратегийн чиг баримжаа нь банкны балансын бүтцийг сайжруулж ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэж байна гэлээ. Сүүлийн 5-6 улиралд дараалан өсөж байгаа төгрөгийн болон ам.долларын бодлогын хүү нь санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлж, маржинд сөрөг нөлөө үзүүлж байгаа хэдий ч, ХасБанк нь чанаргүй активыг бага түвшинд барих замаар эрсдэлийн сангийн зардлыг бууруулж, мөн орлого олдог активт эзлэх зээлийн багцын хэмжээг нэмэгдүүлснээр 2023 оны эхний 2 улирлын цэвэр ашгийн хэмжээ 1 дүгээр улиралд 31.3 тэрбум төгрөг, 2 дугаар улиралд 30.9 тэрбус төгрөг тус тус гарч мөн балансын үр ашиг нэмэгдсэн тухай танилцуулав.

Зээл, санхүүгийн түрээсийн багцын тухайд, зээлийн үйл ажиллагаа нь Иргэдийн банк, Байгууллагын банк, Хаслизинг (Санхүүгийн түрээс) гэсэн үндсэн гурван бизнесийн сегментэд хуваагддаг. 2023 оны эхний 2 улиралд Иргэдийн банкны зээлийн багц 26.0%-иар, Байгууллагын банкны зээлийн багц 8.1%, Хаслизингийн багц 40.8%-иар тус тус өслөө. Тайлант хугацаанд чанаргүй зээлийг бууруулах стратегийн дагуу чанаргүй зээлийг тогтмол бууруулж, чанаргүй зээлийн харьцаа 2.9%-д хүрсэн болохыг дурдав.

ХасБанк нь харилцагчдадаа урт хугацаатай санхүүжилт олгох зорилгоор олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Тэрээр танилцуулгаа үргэлжлүүлэн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийн талаар танилцуулж, Монголбанкнаас доод хязгаарыг 9%-иар тогтоосон байдаг гэв. Мөн системийн нөлөө бүхий банкуудад нөөц интервалын шаардлага нэмж тогтоодог. ХасБанкинд тогтоосон нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хязгаар болон нөөц интервалын нийлбэр 12.5% байна. ХасБанк нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтээр тайлант хугацаанд 19.1% буюу байвал зохих хэмжээнээс 6.6%-иар давуулан хангаж ажилласныг онцолж, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн үзүүлэлтийг байвал зохих хэмжээнээс давуулан хангах нь аливаа болзошгүй эрсдэлийг хүлээх чадвар тэр хэмжээгээр нэмэгддэг, мөн ногдол ашиг хуваарилах боломжийг мөн олгодог тухай тайлбарлав.

Арилжааны банкуудад Монголбанкнаас тогтоосон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийн доод хязгаар 25% байдаг бол манай Банк 36.5%-тай байна.

Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй ногоон бизнес, эко хэрэглээг дэмжих болон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг тухайгаа Гүйцэтгэх захирал онцлов.

Гүйцэтгэх захирал ХасБанкны хүний нөөцийн тогтвортой хөгжлийн бодлогын талаар танилцуулав. ХасБанк үүсгэн байгуулагдсан цагаасаа жендерийн тэгш байдлын бодлогыг хэрэгжүүлж, байгууллагын зөв соёл, үлгэр жишээ сайн засаглалыг хөгжүүлэн бэхжүүлж, шударга тогтвортой хөдөлмөрийн харилцааг үүсгэхэд зорин ажиллаж ирсэн тухай танилцуулав. ХасБанкны ажилтнууд тогтвортой тууштай ажилладаг ба ажилласан дундаж хугацаа 7.8 жил байна. Банк дотроосоо дэвшүүлэх бодлогыг барин ажиллаж ирсэн бөгөөд нийт удирдлагуудын 90% нь дотроосоо дэвшсэн амжилттай байна гэв.

Тэрээр цааш нь зээлжих зэрэглэлийн талаар мэдээлэв. Банк 2008 оноос дэлхийн хамгийн нэр хүндтэй үнэлгээний агентлагууд болох Мүүдис инвестор сервис болон Фитч Рейтингс зэрэг байгууллагуудаар өөрийн зээлжих зэрэглэлийн үнэлгээг тасралтгүй хийлгэж байна. Мүүдис инвестор сервисийн гаргасан ХасБанкны үнэлгээг дурдвал, гадаад валютын зээлжих зэрэглэл B3/NP, төгрөгийн зээлжих зэрэглэл B2/NP, Банкны хадгаламж B3/NP, суурь зээлжих зэрэглэл B3, үнэт цаас гаргачийн зээлжих зэрэглэл B3 болон хэтийн төлөвийг тогтвортой (stable) гэж үнэлсэн тухай танилцуулав. Банкуудын зээлжих зэрэглэлийн тааз харъяалагдах улсынхаа зэрэглэлээр тодорхойлогддог гээд Монгол Улсын зээлжих зэрэглэл нэмэгдэх нь банкууд гадаадаас эх үүсвэр татахад хүүний зардал буурах ач холбогдолтой, мөн банкуудын хоорондох зээлжих зэрэглэлийн үнэлгээний ялгааг илүү бодитойгоор харах боломжтой болох юм гэлээ.

Үргэлжлүүлэн Гүйцэтгэх захирал ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн бүтцийг танилцуулав. Өмнө нь ХасБанкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК (“ТСН”) 12 хувьцаа эзэмшигчтэй, тэдгээрийн 2 нь төрийн бус байгууллага байсан бол одоо 10 хувьцаа эзэмшигчтэй болсон гэлээ. Тэрээр цааш нь Банкны тухай хуулийн шаардлагын дагуу банкны хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах шаардлагыг дурдаж, уг шаардлагын дагуу ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигч болох өөрчлөн байгуулалт хийгдэнэ гэдгийг онцлов.

ХасБанк нь хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсантай холбогдуулан ТУЗ-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар 16 журам, мөн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо (“ЗНДЦУХ”), Эрсдэлийн удирдлагын хороо (“ЭУХ”) болон Аудитын хороо (“АХ”) тус бүрийн бүрэлдэхүүнийг хууль, тогтоомжид нийцүүлэн баталсан талаар танилцуулав.

Дараа нь Гүйцэтгэх захирал гүйцэтгэх удирдлагын багийг танилцуулж, банкинд дунджаар 14 жил ажилласан туршлагатай баг гэдгийг онцлов.

Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтын явцын мэдээлэл

Өнөөдрийн байдлаар ХасБанкны ТУЗ-ийн 11 гишүүний 8 нь ердийн гишүүн, 3 нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг ЗНДЦУХ зохион байгуулж буй бөгөөд СЗХ-ны зөвлөмж, компанийн сайн засаглалын зарчимд үндэслэн ил тод, нээлттэйгээр зарлан сонгон шалгаруулалтыг хийж буй болно.

ЗНДЦУХ-ноос сонгон шалгаруулсан нэр дэвшигчид нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-82 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам”-д заасан ТУЗ гишүүнд тавигдах шаардлага, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А/86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-д заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байх шаардлагатай. Мөн ЗНДЦУХ-ноос ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийг Монголбанкны зөвшөөрлөөр хувьцаа эзэмшигчдийн хуралд санал болгох журамтай.

Иймд, Монголбанкнаас холбогдох зөвшөөрөл авсны дараа ХасБанк ХК-ийн ТУЗ-ийн 12 гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль тогтоомжид бүрэн нийцүүлэн дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулж батлуулна гэлээ.

5. БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Гүйцэтгэх захирал Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг тус тус 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурал баталж, улмаар системийн нөлөө бүхий банкууд хувьцаат компани болж өөрчлөгдөн байгуулагдах шаардлага үүссэн тухай дурдав.

ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хурлын “ХасБанк ХХК-ийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулах тухай” SR-2023-02, “Нийтэд санал болгох зорилгоор ХасБанкнаас хувьцаа нэмж гаргах тухай” SR-2023-03 дугаар тогтоолын дагуу, Монголбанкны 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А-1/374 дугаартай албан бичгээр өсгөн зөвшөөрөл, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 179 дугаартай тогтоолд тус тус үндэслэн ХасБанк нь олон нийтэд зориулан 52,700,000 ширхэг энгийн хувьцааг гаргаж нэг бүрийг нь 677 төгрөгөөр санал болгосон.

ХасБанк 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс 6 дугаар сарын 05-ны өдрийн хооронд анхдагч зах зээлийн арилжаагаа амжилттай явуулж, олон нийтээс 35,677,900,000 төгрөг татан төвлөрүүлсэн.

Нэмж гаргасан хувьцаа буюу 52,700,000 ширхэг хувьцааг нэгж хувьцааны нэрлэсэн үнэ болох 100 төгрөгөөр үржүүлсэн дүн буюу нийт 5,270,000,000 төгрөг нь Банкны Хувь нийлүүлсэн хөрөнгөд нэмж бүртгэгдэх бөгөөд улмаар ХасБанкны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,052,700,000 ширхэг хувьцаанаас бүрдэх 105,270,000,000 төгрөг болж өөрчлөгдөж байна.

Анхдагч зах зээлийн арилжааны үр дүнд татан төвлөрүүлсэн 35,677,900,000 төгрөг болон хувь нийлүүлсэн хөрөнгөд нэмж бүртгэгдэх 5,270,000,000 төгрөг, нийтэд анх удаа санал болгон хувьцаа гаргах ажиллагаатай холбогдуулан гарсан зардал болох 1,638,905,180 төгрөгийн зардлын дүнгийн зөрүү дүн болох 28,768,994,820 төгрөгийг Банкны нэмж төлөгдсөн капиталд бүртгэнэ гэлээ.

Ийнхүү, ХасБанкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 105,270,000,000 төгрөгөөр тогтоон, ХасБанк ХК-ийн дүрэмд тусгах саналыг Хувьцаа эзэмшигчдээр хэлэлцүүлэн, батлуулахаар санал болгов.

6. ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРМИЙН ТӨСӨЛ

Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД (“ХХЗ/ТУЗНБД”) Н.Мөнхцэлмэг хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэндийг хүргэн, Банкны дүрмийн төслийг товч танилцуулав.

Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль 2021 онд батлагдсанаар системийн банкууд нээлттэй хувьцаат компани болох шаардлага үүссэн. Түүний дагуу Хасбанк нээлттэй хувьцаат компани хэлбэрээр өөрчлөгдөн байгуулагдах шийдвэр гаргаж олон нийтэд хувьцаагаа санал болгосон.

Нээлттэй хувьцаат компани болж өөрчлөгдөн байгуулагдсан учраас хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай өөрчлөлтүүдийг тусган компанийн дүрмээ шинэчлэн батлуулах зайлшгүй хууль зүйн шаардлага бий. Иймд дагаж мөрдөх шаардлагатай нэмэлт зохицуулалтуудыг тусгаж, нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг харгалзсан байдлаар дүрмийг шинэчлэн батлах шаардлагатай юм.

Дүрмийн төслийг хөндлөнгийн хуулийн фирм Мелвилл Эрдэнэдалай боловсруулсан. Боловсруулахдаа ХасБанкны хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм, Хасбанкны шууд бус хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан хувьцаа эзэмшигчдийн гэрээнд тулгуурлаж нэмэлт зохицуулалтуудыг тусгах замаар шинэчлэн найруулсан байна.

Дүрмийн төслийг ХасБанкны үнэт цаасны танилцуулгын салшгүй хэсэг болгон олон нийтэд хүргүүлж урьдчилан танилцах боломж олгосон. Олон нийтээс хувьцаа худалдан авсан хувьцаа эзэмшигчид хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа үндэслэсэн тулгуур бичиг баримт тул үнэт цаасны танилцуулгад хавсаргасан байдлаар батлуулах нь маш чухал гэж бид ойлгож байгаа.

Дүрэм нь та бүхний дэлгэцэнд харж буй 13 зүйл, 117 хэсгээс бүрдэх цогц эрх зүйн баримт бичиг болсон.

Хувьцаа эзэмшигчид үнэт цаасны танилцуулгад тусгаснаас эхлээд уг дүрмийн төсөлтэй танилцсан учраас үндсэн зохицуулалтуудыг та бүхэнд товчхон тоймлон хүргэе.

1. Эрх зүйн байдал: Нэгдүгээрт, компанийн дүрэм гэдэг бол тухайн байгууллагыг өөрийн нэрээр эрх эдэлж үүрэг хүлээдэг бие даасан хуулийн этгээд байх эрх зүйн үндэс нь болдог. Манай дүрмийн хувьд хуулийн этгээдийн хэлбэрээ өөрчлөгдсөн байдлаар нь тусгаж “нээлттэй хувьцаат компанийн хэлбэртэй, банкны үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий арилжааны банк” гэж тодорхойлсон байна. Эрх зүйн байдал болон ерөнхий зохицуулалтуудыг дүрмийн 1 болон 2 дугаар зүйлд тусгасан.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгө: Гүйцэтгэх захирлын танилцуулснаар нийт нэмж гаргасан хувьцаанаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг хувь нийлүүлсэн хөрөнгөд тусгасан байдлаар дүрмийн төсөлд буулгасан. Хувь нийлүүлсэн хөрөнгө нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,052,700,000 (нэг тэрбум тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх 105,270,000,000 (нэг зуун таван тэрбум хоёр зуун далан сая) төгрөг байна.

3. Хувьцаа эзэмшигчдийн эрх: Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчдээс ялгарах нэг онцлог бол бусдаас асуулгүйгээр өөрийн хувьцааг чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй байдаг.

Өмчлөлд буй хувьцааны тоогоор хувь тэнцүүлэн санал өгөх, ногдол ашиг хүртэх, Банкны үнэт цаас гаргагчийн хувьд олон нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд хүртээл болгох мэдээлэлтэй танилцах, нэмж гаргасан хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах, татан буулгалтын ногдол хувь хүртэх эрхтэй байна.

4. Хувьцаа эзэмшигчдийн үүрэг: Банкны хувьцаа эзэмшигч байх нь энгийн хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч байхаас ялгаатай. Банкны тухай хуульд зааснаар нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, өөрөөр хэлбэл 5 болон түүнээс дээш хувийг эзэмших бол Монголбанкнаас заавал зөвшөөрөл авдаг журамтай.

Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр худалдан авсан бол Банкны тухай хуулийн дагуу хувьцаа саналын эрхгүй, ногдол ашиг авах боломжгүй болдог үр дагавартай.

5. Засаглалын бүтэц: Сая та бүхэнд хувьцаа эзэмшигчийн дангаар эдлэх эрх үүргүүдийг танилцуулсан бол одоо хувьцаа эзэмшигчдийн хурал буюу банкны эрх барих дээд байгууллагын хувиар банкны шийдвэр гаргалт, засаглалд хэрхэн оролцох талаар тайлбарлая. Засаглалын хувьд удирдлагын бүтэц гурван шаталсан түвшинд хуваагдана. Дээд эрх мэдэл буюу эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

Нийт гаргасан хувьцааны 50%-иас дээш хувийг төлөөлөх хувьцаа эзэмшигчид ирснээр хурал хүчин төгөлдөрт тооцогдоно. Хурал дээр шийдвэр гаргах босгын тухайд асуудлаасаа хамааран өөр байна.

Жишээ нь, ердийн асуудлаар бол хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн 50%-иас дээш хувь баталснаар хүчин төгөлдөр болдог. Харин стратегийн асуудал буюу компанийн үйл ажиллагаа, засаглалд онц чухал асуудлууд дээр дийлэнх олонх буюу 66.67%-иар шийдвэр батлагдана. Харин, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг үнэмлэхгүй олонх буюу 75%-иар шийдвэрлэхээр нэмэгдүүлэн тогтоосон.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна. ТУЗ-ийн болон түүний хороодын бүрэлдэхүүн Компанийн тухай хууль болон Банкны тухай хуулийн аль алиныг хангаж байхаар тусгаж өгсөн. Хурлын бүрэн эрхийн хугацаа 2 жил байна.

Өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах институци нь гүйцэтгэх захирал байна. Гүйцэтгэх захирал нь гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг дангаар хэрэгжүүлнэ. Мөн ТУЗ-ийн даргын үүргийг давхар гүйцэтгэж болохгүй.

6. Стратегийн асуудал: Компанийн тухай хуульд дийлэнх олонхоор шийдвэрлэхээр заасан асуудлууд, мөн ногдол ашиг тараах, үнэт цаас гаргах, өөрийн хөрөнгийн хоёр (2) хувиас дээш дүнгээр хөрөнгө оруулах зэрэг асуудлаар 66.67%-иар шийдвэр гаргана.

Та бүхний харж байгаагаар ерөнхийдөө Төлөөлөн удирдах зөвлөлд харъяалагддаг зарим асуудлууд зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдэгдэхээр болгож хувьцаа эзэмшигчийн шийдвэр гаргах эрх мэдлийг өргөжүүлсэн.

7. Байгаль орчин, нийгмийн бодлого: банк нийгмийн хариуцлага, байгаль орчинд хувь нэмэр оруулах эрмэлзлээ дүрэмдээ мөн зааж өгсөн. Бид дотоод бодлоготой байна, түүнийгээ бодит байдал дээр хэрэгжүүлэх механизмтай байна, нөлөөллийн үнэлгээ хийлгэх журамтай байна гэж заасан. Энэ нь бүгд өнөөдрийн түвшинд банкинд хийгдэж явдаг үйл ажиллагаанууд юм. Мөн та бүхэн байгаль орчин, нийгмийн хариуцлагын тайланг жил бүр нээлттэй олж авч үзэх боломжтой байна.

Дүрмийн төслийг танилцуулж дуусаад тэрээр дүрмийн төслийг баталж өгөхийг хүсэв.

Хувьцаа эзэмшигч Ч.Ганхуяг санал хэлэхээр хүсэлт гаргав. Тэрээр хувьцаа эзэмшигчдийн хурал дээр асуулт асууж хариулт авах тусгайлсан албан ёсны хэсэг дэгт цаашид тусгаж байхыг санал болгоод дараах асуултуудыг асуув:

1. Банкны цахим хуудаст тодорхойлсон эрхэм зорилго нь банкны дүрэмд бичигдсэнээс зөрүүтэй байгаа талаар тодруулга хүсэв.
2. Банкны дүрэмд банкны хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй тохиолдолд гагцхүү санал өгөх, санал хэлэх, Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшүүлэх эрхтэй гэж танилцуулгад дурдах шиг болсон гээд энэ нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндсөн эсэх талаар тодруулав.
3. Банкны дүрмийг англи болон монгол хэлээр үйлдэх бөгөөд англи хэл нь давамгайл байна гэж заасан нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн хувьд хуулийн шаардлагад нийцэж буй эсэхийг асуув.
4. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлд тооллогын комисс нь хараат бус, хөндлөнгийн байна гэж заасан гээд, Банк өөрийн ажиллагсдыг тооллогын комисст томилсон нь тус шаардлагыг хангаж буй эсэхийг тодруулав.
5. ТУЗ-ийн гишүүн Майкл Мадден Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороонд ажиллаж буй нь хуульд нийцэх эсэх талаар асуув.

ХХЗ/ТУЗНБД Н.Мөнхцэлмэг дээрх асуултад дараах байдлаар хариулав.

1. ХасБанк ХК-ийн дүрэм хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэний дараагаар эрхэм зорилго албан ёсоор өөрчлөгдсөнд тооцогдох тул зөвхөн түүний дараа холбогдох өөрчлөлтийг банкны цахим хуудсанд оруулна.
2. Банкны саналын эрх бүхий энгийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад санал оруулах эрхтэй гэж дүрэмд тусгасан нь Компанийн тухай хуульд заасан эрхийг иш татсан хэрэг юм. Энэ нь таны асууснаар хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч гагцхүү санал өгөх эрхтэй гэсэн үг биш болно. Хувьцаа эзэмшигчид хэлэлцэх асуудлаар эзэмшиж буй хувьцааны тоонд хувь тэнцүүлэн санал өгөх, түүнчлэн аливаа асуудлаар санал хэлэх эрх хэзээд нээлттэй.
3. Банкны дүрэмд англи хэлийг давамгайлах тухайд хуулиар хориглосон зохицуулалт байхгүй. Гэхдээ таны саналыг ойлголоо. Цааш уламжлах болно.

4. Компанийн тухай хуулийн 67 дугаарт зүйлийн 67.2 дахь хэсэгт зааснаар хурлаар хэлэлцэх асуудалд шууд холбоотой албан тушаалтныг тооллогын комиссын гишүүнээр томилохыг хориглодог. Иймд томилогдсон тооллогын комиссын гишүүд нь хуулийн шаардлагад нийцэж байгаа болно.
5. ТУЗ-ийн гишүүн Майкл Мадден нь ЗНДЦУХ-ны даргаар томилогдон ажиллаж буй нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа буюу Компанийн тухай хуульд хорооны гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүн байхаас өөрөөр хорооны даргад тусгайлсан шаардлага тавиагүй. Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн сайн кодекст ЗНДЦУХ-ны дарга хараат бус гишүүн байхаар заасан байдаг. Энэ нь хуулийн шаардлага биш боловч бид кодексийн шаардлагыг хангах зорилгоор Банк хөтөлбөр батлан, түүнийхээ дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэх алхмуудаа тодорхойлж хэрэгжүүлэн ажиллаж байна.

6. САНАЛ ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

Танилцуулгуудын дараа, Тооллогын комиссын дарга Э.Ундармаа хурлын шийдвэрлэх асуудалд хэрхэн санал өгөх талаар зааварчилгаа, тайлбарыг хувьцаа эзэмшигчдэд өгөв. Хурлыг цахимаар дамжуулж буй “Хас Meeting” аппликейшнээр дамжуулан санал өгөх дарааллыг дэлгэрэнгүй танилцуулаад ХЭЭБХ-аар хувьцаа эзэмшигчдийн санал хурааж шийдвэрлүүлэх хоёр асуудал байгааг зарлав. Нэгдүгээрт, “Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай тогтоолын төслийг батлах”, хоёрдугаарт, “Банкны дүрмийг батлах тухай тогтоолын төслийг батлах” гэсэн тусдаа асуудлууд байгаа тул тусад нь санал өгөхийг сануулав.

Үргэлжлүүлэн тооллогын комиссын дарга саналаа өгөхөөс өмнө тус дэлгэцийн доор буй санамжтай сайтар танилцахыг зөвлөж, уг санамжид дурдсанаар хувьцаа эзэмшигчийн нэг хувьцаа саналын нэг эрхтэй болохыг мэдээлэв. Энэ нь санал хураалтын ердийн арга юм. Мөн түүнчлэн хэрэв хувьцаа эзэмшигч саналаа өгөхгүйгээр тус аппликейшнээс гарвал тус хувьцаа эзэмшигчийн санал “түдгэлзсэн” гэсэн төлөвтэй болохыг анхааруулав.

Саналаа өгөхдөө “зөвшөөрсөн”, “татгалзсан” эсхүл “түдгэлзсэн” гэсэн гурван сонголтоос аль нэгийг нь сонгож “санал өгөх” гэсэн товчийг дарахад “таны саналыг амжилттай хүлээн авлаа” гэсэн бичиг гарч ирснээр санал Тооллогын комисст илгээгдэх ба та саналаа амжилттай өгч дууссан гэсэн үг гэж тайлбарлав.

Хувьцаа эзэмшигч саналаа аппликейшнээр дамжуулан өгөх бөгөөд хэрэв боломжгүй бол саналын хуудсаар¹ саналаа өгч болно. Хэрэв та саналаа саналын хуудсаар өгөх хүсэлтэй бол хурлын танхимын үүдэнд байрлах бүртгэлийн ажилтанд хандаж саналын хуудас авч саналаа өгч болно гээд саналын хуудсаа битүүмжлэн бүртгэлийн ажилтанд эргүүлэн өгөхийг зөвлөв.

Үүний дараа, Хурлын дарга (i) банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох эсэх тухай болон (ii) ХасБанк ХК-ийн дүрмийг батлах эсэх тухай асуудлуудаар санал хураалтыг эхлүүлэв.

Хурлын дэгийн дагуу завсарлага авч, тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэх ажлыг эхлүүлэв.

7. САНАЛ ХУРААЛТЫН ҮР ДҮН: ШИЙДВЭР

Тооллогын комиссын дарга Э.Ундармаа хувьцаа эзэмшигчдээр батлуулахаар санал болгосон асуудал тус бүрийн санал хураалтын үр дүнг танилцуулав.

¹ ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн R-2023-66 дугаар тогтоолоор батлагдсан ХЭЭБХ-ын саналын хуудсын загварыг тус хурлын тэмдэглэлд хавсаргав.

Санал хураалт #1:

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав. Тус санал нь ХасБанкны зарласан болон гаргасан энгийн хувьцааны тоог нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,052,700,000 (нэг тэрбум тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг болгон тус тус тогтоож, хувь нийлүүлсэн хөрөнгийг 1,052,700,000 (нэг тэрбум тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг гаргасан энгийн хувьцаанаас бүрдэх 105,270,000,000 (нэг зуун таван тэрбум хоёр зуун далан сая) төгрөг болгон нэмэгдүүлэх байв.

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай тогтоолыг батлах асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Хувьцааны тоо	Хувь	Хувьцааны тоо	Хувь	Хувьцааны тоо	Хувь
1,006,691,541	99.81%	29,742	0.00%	1,910,142	0.19%

Шийдвэр #1:

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн, итгэмжлэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.81% (ерэн ес зууны наян нэг) хувийн Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #2:

ХасБанк ХК-ийн дүрмийг батлах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанк ХК-ийн дүрмийг батлах тухай тогтоолыг батлах асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Хувьцааны тоо	Хувь	Хувьцааны тоо	Хувь	Хувьцааны тоо	Хувь
1,006,736,054	99.81%	15,591	0.00%	1,879,780	0.19%

Шийдвэр #2:

ХасБанкны дүрмийг батлах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн, итгэмжлэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.81% (ерэн ес зууны наян нэг) хувийн Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн саналаар батлагдав.



ХАСБАНК

Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн ээлжит бус хурлын тэмдэглэл

ХУРЛЫН ХААЛТ

Хурлын дарга ХЭЭБХ-д оролцсон хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг албан ёсоор хаав.

Гарын үсэг зурсан:

Санжай Гүпта

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
бус хурлын дарга

Гарын үсэг зурсан:

Н.Мөнхцэлмэг

Хууль хариуцсан захирал бөгөөд
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн R-2023-66
дугаар тогтоолын 5 дугаар хавсралт



САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР №1

Компанийн нэр: ХасБанк

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

ХасБанкны хувьцаа эзэмшигчийн ээлжит бус хурал 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 13:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) танхим болон цахим хосолсон байдлаар зохион байгуулагдана.

Д/д	Батлах асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	ХасБанкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай тогтоол	☐	☐	☐
2.	ХасБанкны дүрмийг батлах тухай тогтоол	☐	☐	☐

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: _____ / _____

Бүртгэсэн (үнэт цаасны компани) _____

Саналын хуудсыг хүлээн авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал:

_____ / _____

2023 оны ... сарын ...-ны өдөр

Тайлбар/Санамж:

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) гэж тэмдэглэнэ үү.
2. Та саналаа урьдчилан заасан хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэгт байрлах ХасБанкны төв байр, эсхүл Улаанбаатар хот болон орон нутаг дахь ХасБанкны салбар, тооцооны төвүүдэд цаасан болон цахим хэлбэрээр дамжуулан өгөх боломжтой.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх бол төлөөлөх хүн Монгол Улсын хууль тогтоомжинд нийцсэн итгэмжлэлийг авчран саналын хамт өгсөн тохиолдолд таны санал

хүчинтэйд тооцогдоно.

4. Засварласан, балласан, тэмдэглэгээг буруу үйлдсэн бол саналын хуудас хүчингүйд тооцогдоно.
5. Та саналаа урьдчилан өгсөн тохиолдолд дахин санал өгөх эрхгүй болно.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм / Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____ / _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл:
